



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 1/94

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 19 дүгээр дүгнэлтийн дагуу Төв номын сангийн хуучин барилгын засвар /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлыг 44442129 (дөчин дөрвөн сая дөрвөн зуун дөчин хоёр мянга нэг зуун хорин ес) төгрөгөөр БДЗ ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулахдаа түгээмэл тархацтай барилгын материалыг орон нутгаас худалдан авах заалтыг тусгах, ажил гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3 Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100275